

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 07 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Хөрөнгө оруулалтын чиглэлээр: Аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн XI дүгээр хуралдаанаар орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын явцыг танилцуулан тодотгол хийх тухай асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.

Ковид-19 халдвараас сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх чиглэлээр: Тайлант хугацаанд батлагдсан тохиолдол 3221, эдгэрэлт 2902, вакцинжуулалтын 1-р тунд 37914, 2-р тунд 34525 хүн хамрагдсан. Нас баралт 6 бүртгэгдлээ. Шинжилгээ PCR-18019, түргэвчилсэн 27096 хүнд хийсэн.

Герман улсад үйлдвэрлэсэн Комирнэти вакцины 11788 хүн/тун, Астразенека вакцины 1800 хүн/тун дагалдах хэрэгсэлийн хамт аюулгүй байдлыг ханган тээвэрлэн, нэгж байгуулагуудад вакцин түгээлтийг хийн 21 сум, өрхийн Эрүүл мэндийн төв дархлаажуулалтын ажлыг зохион байгууллаа.

Verocell вакцины I-р тунд 63, II-р тунд 394, Комирнэти вакцины I-р тунд 3330, II-р тунд 3668 хүн хамрагдлаа. Комирнэти вакцинд хамрагдвал зохих 12-17 насны 2677 хүүхэд, 34 жирэмсэн эх, 40 хөхүүл ээж I-р тунд тус тус хамрагдлаа.

Гамшгаас хамгаалах чиглэлээр: Бүх нийтийн амралтын өдрүүдэд Завхан голын эрэг дагуу амарч, зугаалж байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хөдөлгөөнт эргүүлийг 07 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн ажиллуулж, гол, усны ослоос урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг 2754 иргэнд хүргэлээ.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн хашаанд баригдсан хүчилтөрөгчийн үйлдвэр, баллон хадгалах, цэнэглэх, түгээх байранд 07 дугаар сарын 21-ний өдрөөс 23-ны өдрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, илтгэх хуудсыг Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлээ.

Тус аймгийн Халиун сумын Гүү бариач багийн нутаг сумын төвөөс зүүн урд зүгт 70 км, аймгийн төвөөс баруун урд зүгт 40 км-т 07 дугаар сарын 24-ний өдрийн 15:10-15:40 цагийн үед усархаг бороо орж 3 том хүн 1 хүүхэд, 2 айл, 1 автомашин үерт урссан тухай дуудлагыг хүлээн авч, бүлэг ажиллаж 4 цогцос гаргаж, Цагдаагийн газарт хүлээлгэн өгсөн.

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Өлзий булаг багт /сумын төвөөс хойд зүгт 10 км, аймгийн төвөөс урд зүгт 235 км/-т 07 дугаар сарын 24-ний шөнийн 01:10 цагаас өглөөний 10:50 цагийн хооронд бороо орж, автомашин 1 иргэн үерт урссан тухай дуудлагыг хүлээн авч, Эрэн хайх, аврах бүлэг ажиллаж 1 цогцос олж цагдаагийн газарт хүлээлгэн өгсөн.

Гамшгийн шуурхай удирдлагын газар, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар, Ус цаг уур орчны шинжилгээний газраас ирсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээллийг албан бичиг болон цахимаар авч 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Аймгийн Онцгой комиссын гишүүд, малчид, иргэдэд нийт 12 удаа, 1440 иргэнд, коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 удаа, 1200 хүнд “Багц мессеж”-ээр, байгууллагын ga.nema.gov.mn цахим хуудас, аймгийн цахим хаягаар мэдээллийг байршуулж, “Миний нутаг” телевизээр 8 удаагийн давтамжтайгаар мэдээллийг хүргэлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 76.59, 72.35 хувийн хэрэгжилттэйгээр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем unelgee.gov.mn/-д заалт бүрээр тус тус байршууллаа.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох хэлтэс, агентлагт зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

Хүнхэр зуслангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн Боловсролын сайд, Соёлын сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Барилга хот байгуулалтын сайд, Эрчим хүчний сайд, Уул уурхайн сайд нарын аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт тайланг хүргүүллээ.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт: Тайлант хугацаанд 4 өргөдөл бичгээр ирснээс 3 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл хяналтын шатандаа, хугацаандаа судлагдаж байна. Шийдвэрлэлт 75%, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног, хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд тайлант хугацаанд нийт 44 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгсөн 31 гомдол, санал, хүсэлтийг E-office программд бүртгэн, холбогдох байгууллагуудад шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллалаа. Шийдвэрлэж хариу өгсөн 14, хугацаандаа судлагдаж байгаа 17 өргөдөл байна. Шийдвэрлэлт 45,16%-тай байна.

E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системээр нийт 54 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд нэг шатлалаар олгож байна.

2021 оны 07 сарын 01-ний өдрөөс төрийн мэдээлэл солилцооны Хур системээс гарч байгаа Улсын бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа мэдээллүүдийг оператороор болон E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн портал сайтаар үнэ төлбөргүй олгох болсон ба тайлант хугацаанд иргэдийн ихэвчлэн авдаг 8 төрлийн төрийн цахим мэдээллийн үйлчилгээг 8 иргэнд төлбөртэй, 38 иргэнд төлбөргүй, нийт 46 лавлагаа мэдээлэл гарган үйлчилж, 5500 төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээ.

Сумдын цахим мэдээлэл лавлагааны дүнг нэгтгэж, тайлан мэдээг Харилцаа холбооны зохицуулах хороонд сар бүрийн 05-ны дотор хүргүүлж байна.

Төрийн цахим үйлчилгээний E-mongolia сайтыг иргэдэд танилцуулах, шаардлагатай лавлагаа тодорхойлолтуудыг нэг шатлалаар богино хугацаанд өгөх, цахим порталын хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс Үйлчилгээний нэгдсэн төвөөс иргэдэд мэдээ мэдээлэл, заавар зөвлөмж өгч, шаардлагатай тохиолдолд бүртгэл үүсгэн, лавлагаа тодорхойлолтуудыг 138 иргэнд үнэ төлбөргүй гарган үйлчиллээ.

Аймгийн нийгэм, эдийн засгийн эхний хагас жилийн мэдээллийг гаргаж, тархаалаа.

“Жендэр ба хүрээлэн буй орчин” судалгааны хүрээ бэлтгэхэд нийт 460 хүнтэй утсаар холбогдон утас хаягийг тодруулсан ба “Бичил уурхай 2021” судалгааны хүрээ бэлтгэхэд нийт 18 сумаас мэдээг бүрэн авч ҮСХ-д тус тус хугацаанд нь дамжууллаа.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Архивын чиглэлээр: Архивын баримтаас лавлагаа авах иргэдийн хүсэлтийн дагуу 159 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар нийт 1080 хуудас баримтг хувилж, 1256.0 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 5 ажилтныг Архивын тасагт ажиллуулахаар томилуулж, орон тоог нэмэгдүүлээ.

Цахим хэлбэрт шилжүүлсэн 95 хөмрөгийн 285 дансны баримтыг цаасан бүртгэлтэй тулган шалгалаа.

Архивын зориулалтын барилгын техникийн нөхцөл, ажлын даалгавар, архитектор төлөвлөлтийн даалгаврыг аймгийн Газрын харилцаа, хот байгуулалтын газар болон холбогдох байгууллагуудаар гаргуулан зураг төслийг “ББСМО” ХХК-д хүргүүлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс: Иргэний бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай чирэгдэлгүй, чанартай хийж цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжилтыг хийж байна. Тайлант хугацаанд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлээр 126 бүртгэл, 325 лавлагаа олголт, 12 иргэнд гадаад паспорт, 251 иргэнд иргэний үнэмлэх тус тус олголоо. Иргэд хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 267 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэлээ. Иргэд хуулийн этгээдээс бүртгэлийн үйлчилгээний хураамж 2599.6 мянга, улсын тэмдэгтийн хураамж 53.0 мянга, татварын орлого 26631.9 мянган төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлээ. Тайлант хугацаанд шинээр бүртгүүлж хуулийн этгээдийн гэрчилгээ авсан 9, дахин олгосон гэрчилгээ 7, нийт 16 гэрчилгээ олгож, бүртгэлээ.

Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, журам зөрчсөн үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, 20 иргэнд 400.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан ба Иргэний бүртгэлийн чиглэлээр 152, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 10, Хуулийн этгээд 10, нийт 13-н дүгнэлтээр зөрчлийг арилгаж шийдвэрлэлээ.

Цагдаагийн газар: Тайлант хугацаанд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 997 гомдол, өргөдөл, мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 274, зөрчлийн шинжтэй 723 гомдол, мэдээлэл байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 168 нэгжээр буюу 20.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 274 буюу 90.1 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлээд байна.

Аймгийн хэмжээнд төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмч хөрөнгөд 243.5 сая төгрөгийн хохирол учирсан 124 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал хэрэг 23 буюу 22,8%-иар өсч, учирсан хохирол 89.4 сая төгрөгөөр буюу 26,8%-иар буурсан үзүүлэлттэй байна.

124 гэмт хэрэгт нийт 99 иргэн холбогдож, гэмт хэргийн улмаас 6 иргэн нас барж, 49 иргэн гэмтсэн байна.

Хөнгөн гэмт хэрэг 97 бүртгэгдсэн нь 25 нэгжээр буюу 83,3 хувиар, мөрдөн байцаалтын хэрэг 55 бүртгэгдэж 25 нэгжээр буюу 83,3 тус тус өсч, хэрэг бүртгэлтийн хэрэг 69 бүртгэгдэж 2 нэгжээр буюу 2,8 хувиар, хүнд гэмт хэрэг 27 бүртгэгдсэн нь 2 нэгжээр буюу 6,9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 40.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Нийгмийн хэв журам зөрчсөн 7096 зөрчил илрүүлэн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3891 буюу 35,4 хувиар, 7064 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3885 буюу 35,5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчил гаргасан 6763 иргэн, хуулийн этгээдийг 267884,0 мян төгрөгөөр торгох, 140 хүнийг баривчлах, 161 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан.

Нийт зөрчлийн 396 буюу 5,5 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил үйлдсэн байна.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн төсөвт 4597.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 5220.6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 113.5 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 1118.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 1126.5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 100.7 хувиар тус тус биелүүллээ. Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 07 дугаар сарын санхүүжилтыг хуваарийн дагуу сумдад 1265.0 сая төгрөг, шууд харилцагч байгууллагуудад 940.0 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургуулиудад 2256.0 сая төгрөг, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 892.0 сая төгрөгийг тус тус олгон, зориулалтын дагуу зарцуулж байна.

Худалдан авах ажиллагаа: Аймгийн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд 87 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс 71 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэл 81.6 хувьтай байна.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам болон Барилгын хөгжлийн төвтэй зөвшилцөн орон нутагт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явцын талаар мэдээлэл солилцож, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээ авч ажиллахаар боллоо.

"Газар тариалан жимс жимсгэнэ" төслийн хүрээнд Монгол-Германы "Тогтвортой хөдөө аж ахуй" төслийн дэмжлэгээр "Экологижсон газар тариалангийн зохистой дадал" сургалтыг 2021 оны 07 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Тайшир сумд зохион байгуулан зорилтот 12 сумын хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн болон тариаланчдын төлөөллийг оролцуулж, чадавхжууллаа.

Мал эмнэлгийн чиглэлээр: Мал эмнэлгийн газрын хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа, отор нүүдэл хийж байгаа малчин өрх, малын тоон судалгаа болон тус газрын 2 дугаар улирлын санхүүгийн тайлан, бичмэл тайланг Мал эмнэлгийн ерөнхий газарт тус тус хүргүүллээ.

Мал эмнэлгийн ерөнхий газар болон Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, Малын эрүүл мэнд төслөөр "Мал эмнэлгийн нэгдсэн систем"-ийн хэрэглээг сайжруулахад зориулан 8.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдлээ.

Мал угаалгын ажлыг зохион байгуулах тухай сумын Засаг дарга нар захирамж гарган, мал угаалгах ажлыг эрчимжүүлж, 7 хоног бүр явцын мэдээ авч нэгтгэн Мал эмнэлгийн Ерөнхий газарт мэдээлж байна. Тайлант хугацаанд 13 сумд мал угаалгын ажил эхэлжж, 1150 өрхийн 139930 хонь, 203740 ямаа, 4410 үхэр, нийт 348080 мянган толгой мал угаалгад хамрагдаад байна. 2021 онд 1909.9 сая толгой мал угаалгад хамрагдахаас 348.1 мянган толгой мал хамрагдаж гүйцэтгэл 18.2 хувьтай байна.

Мал эмнэлгийн гарал үүслийн цахим гэрчилгээг 338 адуу, 852 хонь, 1992 ямаа, нийт 3182 толгой малд, 80 кг мах, 55963 кг хонины ноос, 600 кг тэмээний ноос, 2000кг ноолуур, нийт 58613 кг ноос, ноолууранд тус тус бичиж, тээвэрлэгдсэн байна.

Дэлгэр, Тайшир сумдын мэл эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирүүлсэн 937 хээлтүүлэгчийн ийлдэсний дээжид бруцеллөз өвчнийг илрүүлэх розбенгалын шинжилгээ хийж, бруцеллөз өвчний үүсгэгч илрээгүй тул шинжилгээний хариуг тухайн сум орон нутагт нь хүргүүллээ.

ТАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын тусгай хамгаалалттай газрын судалгааг 12 сумын 485 нэгж талбар газарт хянаж засварлан Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүллээ.

Орон сууц, үйлчилгээний зориулалтаар 3 иргэнд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан, 8 иргэнд www.egazar.gov.mn сайтаас лавлагаа олголоо.

“Сумдын шинэчлэл хөдөөгийн хөгжил” төслийн хүрээнд Бигэр, Цогт сумдад баригдах 120 айлын орон сууц, ариутгах татуургын төв шугам, цэвэрлэх байгууламж барих газрын байршлыг газар дээр нь зохиогч, гүйцэтгэгч, захиалагч талууд ажиллан зөвшилцөн цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэн шийдвэрлэлээ.

Мөн Бигэр, Цогт, Цээл, Төгрөг, Шарга сумдад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламж, их засварын ажлын явцтай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

Эрүүл мэндийн чиглэлээр: Цогт, Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвд 2021 оны 07 дугаар сарын 27- ны өдрөөс 30-ны өдрүүдэд “Коронавируст халдвар (COVID-19)-ын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ,халдвар сэргийлэлт, хяналт, эмнэлгийн ажилтны сэтгэл зүйн талаар мэдээлэл хийж, өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх, тусгаарлах байрны зохион байгуулалт, тандалт судалгааны талаар ажлын байранд мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Коронавируст COVID-19 халдвар батлагдсан 101 иргэнийг эрэмбэлэн ангилж, Нэгдсэн эмнэлэг, УАУТ, Эрүүл-Ирээдүй эмнэлгүүдэд хуваарилан хэвтүүлж, эмчилгээ үйлчилгээ үзүүлж байна.

Вакцинжуулалтад бүрэн хамруулах зорилгоор 1-р тунгаа хийлгээд 2-р тунгаа хийлгэх хугацаанаас хоцорсон иргэдийн судалгааг гаргаж байна.

Ковидын халдварын 1412 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, тандалт хийлээ. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтал 2879 хүнийг 7 хоног гэрээр тусгаарлан тандалтын шинжилгээнд хамрууллаа.

Боловсролы чиглэлээр: Тус аймгийн боловсролын салбарт шаардлагатай

тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын 2022 оны төсөвт тусгуулан шийдвэрлүүлэхээр Боловсролын яамны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн газарт хүргүүллээ.

2022 оны төсвийн төслийг нэгж байгууллагуудаас цахимаар хүлээн авч БШУЯ-д хүргүүллээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлж, тэдний гэр бүлд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, нийгэмсэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх зорилгоор “ОДОО АРГА ХЭМЖЭЭ АВЪЯ: ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАЯ!” арга хэмжээг зохион байгуулж, 07 дугаар сарын 23-ны өдөр “Хан-Алтай” ресурс, “Болд гент болд” алтны уурхай, Наран, Рашаант багийн нутагт алт олдворлож байгаа газруудад хяналт тавьж, 130 иргэн, 7 хүүхдэд зөвлөгөө зөвлөмжийг өгч, гарын авлага брошурыг тарааж, 15 иргэнээс гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг хандлагыг тодорхойлох асуулга авч, үйл ажиллагаандаа тусган ажиллалаа.

Дэлгэр сумын Гуулин тосгонд зохион байгуулагдсан уралдаанд хүүхэд хамгааллын баг ажиллаж уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж, 6 насны төрөлд 558 морь уралдаж, 296 унаач хүүхэд оролцсон бөгөөд 6 хүүхэд мориноос унаж хөнгөн бэртэл авсныг эрүүл мэндийн анхан шатны үзлэг хийлгэж, эцэг, эх, асран хамгаалагчдад нь хүлээлгэн өгсөн.

Есөнбулаг сумын иргэдийн гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг хандлагыг тодорхойлох асуулгыг Есөнбулаг сумын 400 иргэнийг хамруулан 07 дугаар сарын 26-ны өдрөөс 09 дүгээр сарын 30-ны өдрүүдэд үе шаттайгаар зохион байгууллахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд гар аргаар алт олборлож буй 15 иргэн, Баяншанд багийн 40 иргэнийг санал асуулгад хамруулж, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх гарын авлагыг иргэдэд хүргэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Ойн тухай, Байгалийн ургамлын тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулах, байгалийн нөөц баялагийг хууль бусаар ашиглах явдлыг таслан зогсоох, сургалт сурталчилгааг иргэдэд тогтмол хүргэх, мэдээлэх зорилгоор аймгийн хэмжээнд хийх эргүүл, хяналт шалгалтын ажлыг 2021 оны 7 дугаар сарын 20-ноос 2021 оны 10 дугаар сарын 15 хүртэл зохион байгуулахаар холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өглөө.

Тайлант хугацаанд Хөхморьт сумын тооллого судалгаа, худаг паспортжуулах ажлыг эхлүүлээд байна. Мөн Сангийн далай нууранд сүүлийн 3 жил усны шувуу үхэж байгаа шалтгааныг зөв тодорхойлох зорилгоор зураглал гарган мэдээлэл цуглуулж, нуурын судалгааны ажлын зөвлөмжийг үндэслэн цаашид авах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, эрдэмтэн судлаачидтай хамтран 07 дугаар сарын 27-ны өдрөөс 07 дугаар сарын 30-ны өдрүүдэд газар дээр нь очиж ажиллалаа.

Тус аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг шууд гэрээ байгуулах эрх олгогдсон аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/325 дугаар захирамжийн дагуу “ОАСИС БЕАР” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүллээ.

Сутай хайрхан уулын тахилгын арга хэмжээнд зориулан 100 ширхэг хогийн савны материалыг авч бэлэн болголоо.

Уул уурхайн чиглэлээр: Тус аймгийн Цогт сумын Баян-Улаан багийн “Цагаан толгойн огторго”, Төгрөг багийн “Өлгий”, Чандмань сумын Өлзийбулаг багийн Самдандамба уулын “Элсний ам” нэртэй газрыг тус тус аймгийн тусгай хэрэгцээнд авахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, 2021 оны 22, 23 дугаар тогтоолуудаар баталгаажуулан Кадастрын бүртгэлийн системд бүртгүүлэхээр Ашигт малтмал, газрын тосны газрын геологи, уул уурхайн кадастрын хэлтэст хүргүүллээ.

НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 18 объектод, зөвлөн туслах үйлчилгээг 14 объектод, 3 төрлийн урьдчилан сэргийлэх шалгалтад 26 объектыг хамруулан нийт давхардсан тоогоор 58 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 5 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ковидын нөхцөл байдалтай уялдуулан Улсын онцгой комиссын 41 дүгээр тогтоолын биелэлтэд 13 хүнсний дэлгүүрийг хамруулан хяналт хийж, 90 зөрчлийг илрүүлж, 20 зөрчлийг газар дээр нь арилгууллаа.

Сумдаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хугацаа дууссан бараа бүтээгдэхүүнд хяналт тавьж, 9 хүнсний дэлгүүрт 15 төрлийн 811.0 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг хураан авч, устгалын комисст устгуулахаар хүлээлгэн өглөө.

Аймгийн Засаг даргын шийдвэрийн хүрээнд Улсын онцгой комиссын даргын баталсан 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Түр журмыг шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу 3 халуун усны газар, 29 хоол үйлдвэрлэл, баар, караокены үйл ажиллагаа эрхлэгч нартай хариуцлагын гэрээ байгуулж, зөвлөмж хүргүүллээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

